

**2018 ОНООС ЭХЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙН ЧИГЛЭЛҮҮД**

№	Төслөөр шийдвэрлүүлэх асуудлууд	Үр дүнгийн талаарх төсөөлөл
Байгаль орчин, аялал жуулчлалын яам		
1.	Байгалийн бүс, бүслүүрийг төлөөлөх нууруудын усны тэнцэл, тэдгээрийн экосистем, нөөцийг зохистой ашиглах, хамгаалах судалгаа 2018-2020	- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг нарийвчлан судалж, үр дагаврыг бууруулах, нууруудыг сэргээх хувилбар боловсруулах - Мөстөл, мөсөн голын эхтэй зарим нууруудад ус хуримтлуулах боломжийн урьдчилсан судалгаа хийх - Татмын нууруудад ус дөхүүлэх, экосистемийг сэргээх арга хувилбарыг боловсруулах - Хээр, заримдаг цөлийн бүсийн нууруудын экосистемд түшиглэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хувилбарыг турших, технологи боловсруулах - Байгалийн бүс, бүслүүрийг төлөөлөх нуур, голын сав газарт усны тэнцлийн элементүүдийн үнэлгээг хийх, ашиглалт, хамгаалалтын арга боловсруулах
2.	Арьс шир боловсруулалтын явцад бий болдог уураг агуулсан хатуу хаягдлыг дахин ашиглаж, шувуу болон гэрийн тэжээмэл амьтны тэжээлийн бордоо үйлдвэрлэх технологи боловсруулах 2018-2020	- Арьс ширийг махлах, хусах, захлах болон бусад технологийн механик процессын үед бий болдог хатуу хаягдалд агуулагдаж байгаа эрдэс, уургийн найрлагыг тогтоох - Арьс шир боловсруулалтын явцад махлах машинаас гарсан халим, зах годны хэсэг болон бусад хатуу хаягдлаар желатин, тэжээлийн бордоо хийх технологи боловсруулах - Органик идээлгэтэй савхины зоргодсоор шувуу, гэрийн тэжээмэл амьтны тэжээлийн бордоо хийх түүхий эдийн тохиромжит горимыг тогтоох - Шувуу болон гэрийн тэжээмэл амьтны тэжээлийн бордооны үндэсний стандарт боловсруулах, батлуулах

		- Шувууны тэжээлийн бордооны үйлдвэрлэлийн талаар технологийн зөвлөмж боловсруулах - Желатин, тэжээлийн бордооны технологид ус, эрчим хүч хэмнэсэн эко-үйлдвэрлэл бий болгох - “<i>REACH</i>” зөвлөмжид нийцсэн желатин, тэжээлийн бордоо үйлдвэрлэж үндэсний шувууны аж ахуйг хангах, импортыг орлох органик тэжээлийн бордоо үйлдвэрлэх технологи
3.	Хөвсгөл нуурын Байгалийн цогцолборт газрын экосистемийн үнэ цэнийг тодорхойлох, экосистемийн үйлчилгээний төлбөр (<i>PES</i>)-ийг тооцох судалгаа 2018-2020	- Хөвсгөл нуурын Байгалийн цогцолборт газрын экосистемийн үнэ цэнэ, үйлчилгээний төлбөрийг тооцож байгаль орчин, экологи, экосистемийн менежментийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодлого, төлөвлөлт боловсруулалтын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах - Байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдлын шууд болон шууд бус үнэлгээ, зохицуулах үйл ажиллагааг олон параметрээр тооцон Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг боловсруулах - Хөвсгөл нуурын Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн үнэ цэнийг тодорхойлох экосистемийн үйлчилгээний төлбөрийг тооцон гаргах - Хөвсгөл нуур, орчмын нутгийг дархлан хамгаалснаар Монгол улсын байгаль орчин-нийгэм-эдийн засагт орж буй ач холбогдлыг тодорхойлох, улмаар ямар хэмжээний баялгийг хамгаалж, ашиглах боломжтой байгааг тодорхойлох - Экосистемийн үйлчилгээ, тухайлбал: ой, агаар, ус, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөцийн экосистемд үзүүлж буй нийгэм-эдийн засаг, экологийн ач холбогдлыг үнэлэх - Хөвсгөл нуурын Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үнэ цэнийг тодорхойлж, хамгаалалтын менежментийн үйл ажиллагаатай уялдуулах зөвлөмжийг боловсруулах
4.	Говь, хээрийн бүсийн ашиглалтанд өртөмтгий, устгах аюулд ороод байгаа Орос махирс (<i>Lycium ruthenicum</i>)-ыг биотехнологийн аргаар	- Говь, хээрийн бүсийн ашиглалтад өртөмтгий, устгах аюулд ороод байгаа Орос махирс (<i>Lycium ruthenicum</i>)-ын нөөцийн судалгаа - Орос махирсын бичил ургамланцаруудыг биотехнологийн аргаар (<i>in vitro</i>) гарган авах - <i>In vitro</i> орчинд гарган авсан ургамланцарыг байгалийн нөхцөлд дасган тарималжуулах арга, технологи

	тарих, хамгаалах, нөхөн сэргээх аргачлал боловсруулах 2018-2020	- Үрээр байгалийн нөхцөлд үржүүлэн соёололтын эрчмийг туршиж, тарималжуулахад тохиромжтой орчин, усалгааны горимыг тогтоох - Байгалийн ургамал, уламжлалт болон биотехнологийн аргаар тарималжуулсан ургамлын дээжинд биологийн идэвхит нэгдлийн агууламжийг харьцуулан судлах - Тухайн зүйл ургамлыг тарималжуулах арга технологи аргачлал, зөвлөмж боловсруулах
Гадаад харилцааны яам		
5.	Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хэтийн төлөв, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын талаар Монгол Улсын баримтлах бодлого 2018	- Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд аюулгүй байдлаа баталгаажуулах, эдийн засгийн үр ашиг хүртэх, зах зээлээ тэлэх бодит боломжуудыг тогтоох
Сангийн яам		
6.	Татварын бодлого, багц хуулийн шинэчлэл эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа 2018-2019	- Татварын бодлогын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл - Татварын бодлогын улсын төсөвт болон татвар төлөгчдөд үзүүлэх нөлөө - Татварт нөлөөлж буй хүчин зүйлүүдийн судалгаа - Татварын бодлого шийдвэрлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлох - Татварын орчны эрх зүйн байдлын судалгаа - Татварын ачааллын харьцуулсан судалгаа - Татварын хөрөнгө оруулагчдад үзүүлэх нөлөөлөл - Татварын багц хуулийн шинэчлэх үндэслэл, шаардлагын судалгаа - Татварын багц хуулийн шинэчлэл эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үр дүнгийн судалгаа, дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн яам		
7.	Хилийн заставын барилга байгууламжийн халаалтад нарны эрчим хүч ашиглах туршилт, судалгаа 2018	- Хилийн заставын 33х12, 24х9 метрийн хэмжээтэй, нийт 1000 м² талбай бүхий барилга байгууламжуудын дулаан алдагдлыг тодорхойлох аргачлал - Нарны эрчим хүчээр ажилладаг ус халаах төхөөрөмж ашиглан халаалтын асуудлыг шийдвэрлэх тооцоо судалгаа хийх - Нарны эрчим хүчээр ажиллах ус халаах төхөөрөмж, системийн туршилт судалгаа, өртөг зардлын тооцоо, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зөвлөмж
8.	Говь цөлийн бүсийн заставын ундны усны хатуулгийг бууруулах зориулалт бүхий техник, хэрэгслийг нэвтрүүлэх туршилт судалгаа 2018	- Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн сонголт, харьцуулсан судалгаа - Хилийн заставын ундны усны хоногийн хэрэглээний 4-6 м³ усыг цэвэршүүлэх, хатуулгийг бууруулах төхөөрөмжийг суурилуулан туршиж, эдийн засгийн үр ашгийг тооцох - Судалгааны үр дүнд тулгуурлан ундны усны хатуулгийг бууруулах зориулалт бүхий төхөөрөмжийг нэвтрүүлэх техник, эдийн засгийн тооцоо, зөвлөмж гаргах
9.	Дуу авиа судлалыг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ашиглах нь 2018-2019	- Дуу авианы адилтгалын шинжилгээний шинэ арга боловсруулах - Монгол хүний ярианы хэв загвар, ярианы гүйцэтгэлийн онцлогийг судлах - Дуу авианы адилтгалын шинжилгээний харьцуулалтын системийн аргачлал, стандарт боловсруулах, батлуулах - Ярианы хэлний авианы дуудлагын бүтцийг судлах - Авианы дуудлагын нарийн хэмжих шалгуурыг тогтоох - Хэл ярианд спектрийн анализын судалгаа хийх - Хэлэхүйн интерактив программыг нутагшуулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх
10.	Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилт, тулгамдсан асуудал 2018-2019	- Олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах арга, нэгдмэл байр суурь, аргачлал төлөвшүүлэх, олон улсын гэрээнд нэгдэн орох, олон улсын гэрээг байгуулах асуудлаас эхлэн тухайн олон улсын гэрээг хэвлэн нийтлэх, таниулан сурталчлах, хэрэгжүүлэх арга зам, үр нөлөөг судлах - Монгол Улсын байгуулсан, нэгдэн орсон гэрээний системчлэл, ангиллын асуудал, үндэсний шүүхээс хэрэглэж буй байдал, олон

		улсын гэрээг нийтлэх асуудал, хүртээмж, хэрэгцээ шаардлагын судалгаа - Олон улсын гэрээг хуулийн байгууллага, шүүхэд хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх, тайлбарлан таниулах, шүүхийн болон судалгааны эргэлтэд оруулах арга зам - Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ тэдгээрийн хэрэгжилтийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлох замаар олон улсын гэрээний хэрэглээг шүүхийн болон төрийн үйл ажиллагааны бусад хэрэглээнд нэвтрүүлэх арга - Монгол Улсын олон улсын гэрээг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хангах нөхцөлийг бүрдүүлэх
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам		
11.	Бага насны хүүхэдтэй ажиллах багш нарын мэдлэг, чадварыг мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан тасралтгүй сайжруулах механизмыг бүрдүүлэх нь 2018-2020	- Сургуулийн өмнөх бага насны хүүхдийн мэдлэг чадварыг тасралтгүй сайжруулах чиглэлээр бий болгосон цахим контентүүдэд нөхцөл байдлын шинжилгээ хийсэн байх - Бага насны хүүхдийн боловсролын мэдээллийн платформ бий болгох хэрэгцээг тодорхойлсон байх - Бага насны хүүхэдтэй ажиллах багш, эцэг эхэд зориулсан цахим контентийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох - Контентэй ажиллах гарын авлага боловсруулах - Цахим контентийг тасралтгүй хөгжүүлэх, сайжруулах стратегийг боловсруулсан байх - Цахим контентийг ашиглан сургалтын хөтөлбөрөө сайжруулах арга зүй, аргачлал боловсруулах

12.	Сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг шинэчлэн боловсруулах 2018-2019	- Өмнө хэрэгжиж байсан сургуулийн өмнөх боловсролын стандартад нөхцөл байдлын шинжилгээ хийж, стандартыг сайжруулах, шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байх - Бага насны хүүхдийн хөгжлийг 3 айгаар /эрүүл мэнд, бие бялдар, сэтгэц оюун ухаан/ тодорхойлох сорилыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах - Сорилын стандартуудын төсөл боловсруулсан байх - Стандарт сорилуудыг түүврийн аргаар туршсан байх /1000-аас доошгүй бага насны хүүхдийг хамруулсан байх/
13.	Хүүхэд, залуучуудад мэргэжил сонголтын болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцооны загвар боловсруулж, арга зүйг хөгжүүлэх 2019-2020	- Монголын хүүхэд, залуучуудад мэргэжил сонголтын болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байх - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцооны загвар хувилбарыг боловсруулсан байх - Хүүхэд залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжлээ сонгоход туслах арга зүй, боловсруулсан байх - Арга зүйг хэрэгжүүлэх жишиг сорилуудыг боловсруулсан байх - Жишиг сорилыг түүвэр судалгааны аргаар туршсан байх - Ерөнхий боловсролын сургуульд мэргэжил сонголтын зөвлөгөө өгөх
14.	Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа 2018	- Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагаа, үйлчилгээний байдалд дүн шинжилгээ хийх, соёлын үйлчилгээний хүрэлцээ, хүртээмж, чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох - Соёлын төв, соёлын ордны орчин, хүний нөөц, үйлчилгээнд тавигдах олон улсын жишиг стандартуудыг судалж, Монгол Улсын хэмжээнд нэвтрүүлэх боломжтой стандартуудыг тодорхойлох - Олон улсын соёлын үйлчилгээний үнэлгээний аргачлал, зааврын судалгаа - Соёлын үйлчилгээний үр дүнг үнэлэх аргачлал, үйл ажиллагаа, үйлчилгээг боловсронгуй болгох санал, зөвлөмж - Соёлын ордон, соёлын төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, боловсронгуй болгох жишиг загвар боловсруулах - Соёлын ордон, соёлын төвөөс зохион байгуулах жишиг сургалтын техник, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг тогтоох, турших

15.	Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлыг хэмжих судалгааны арга зүйг боловсруулах 2018	- Хүн амын эрүүл аж төрөх амьдралын хэв маягийн талаарх мэдлэг боловсролын түвшин, зорилтот бүлгийг тогтоох тандалт судалгаа - Идэвхтэй дасгал хөдөлгөөний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох аргачлал боловсруулах /үүнд: шалгуур үзүүлэлтүүдийг тооцоолох асуумж, удирдамж, заавар/ - Аргачлалын дагуу 5000-аас доошгүй хүнээс түүвэр судалгаа хийх - Идэвхтэй дасгал хөдөлгөөний талаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд хүн амын дунд хийгдвэл зохих арга хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр зөвлөмж гаргах - Зорилтот бүлгүүдийг халдварт бус өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх дасгалын хөтөлбөр боловсруулах - Судалгааны үр дүнгийн дагуу бодлого боловсруулагч, хүн ам, зорилтот бүлгүүдэд зориулсан зөвлөмж боловсруулах
16.	Яамны дотоод төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлагнал, үнэлгээний системийг боловсронгуй болгох 2018	- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон бусад үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжид заасан үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөлтийг боловсруулах нэгдсэн системийг хөгжүүлэх - Тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрээр тайланг нэгтгэх, статистик боловсруулалт хийх, мэдээллийн санд хандах, төлөвлөлт, тайлагналын явцыг хянах системийг боловсруулах
17.	Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үзүүлэлтүүдийг тооцоолох аргазүй, аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, зааврыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох нь 2018	- Шинжлэх ухаан, технологийн статистикийн одоогийн мөрдөж буй маягтуудад дүн шинжилгээ хийх - Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн тодорхойлох - Статистикийн мэдээллийн урсгалыг тодорхойлох - Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн маягтыг шинэчлэх санал, заавар боловсруулан, 2017-2018 оны статистикийн үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцоолох - Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийг тархаах асуудлыг боловсронгуй болгох /статистикийн эмхтгэлд оруулах мэдээллийн агууламж, дизайныг өөрчлөн шинэчлэх/

		- Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийн арга зүй, аргачлалыг батлуулах зөвлөмж боловсруулах
Зам, тээврийн хөгжлийн яам		
18.	Идэвхижүүлсэн эрдэс нунтаг ашиглан асфальтбетон хучилтын бат бэхийг сайжруулах судалгаа 2018-2020	- Идэвхжүүлсэн нунтаг хэрэглэж асфальтбетоны бат бэх чанарыг дээшлүүлэх, идэвхжүүлсэн хольцын технологийн горимыг тогтоох судалгаа - Идэвхижүүлсэн хольцийг ашиглан хүйтний улиралд асфальтбетон хучилтын бат бэхийг сайжруулах технологи боловсруулах - Этилен-пропилений резинэн уусмалын хольц бүхий битумын технологи боловсруулах - Асфальтбетоны хольцонд эрдэс нунтаг, шохойн чулуу, доломит, шохойн чулууны бэлдмэл зэргийг ашиглан авто замын ашиглалтыг дээшлүүлэх технологи - Идэвхжүүлсэн эрдэс нунтгийг асфальтбетон хучилтад хэрэглэн, асфальтбетон дахь битумын орцыг бууруулах технологийг боловсруулах
19.	Нисэхийн авионикийн технологийн сургалтыг боловсронгуй болгох судалгаа 2018-2020	- Нисэхийн авионикийн технологийн лаборатори байгуулах - Авионикийн чиглэлийн инженер техникийн ажилтныг бэлтгэх сургалтанд олон улсын дэвшилтэт технологи нэвтрүүлэх - Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагаас тавигдах шаардлага болон Монголын иргэний агаарын тээврийн багц дүрмийн шаардлагад нийцүүлэн сургалтын технологийг боловсронгуй болгох
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		
20.	Ионжуулсан шүлтлэг ус /рН10-12/ ашиглан зэс, молибдений хүдрийн баяжуулалтаас молибдений гарцыг нэмэгдүүлэх технологийн судалгаа 2018-2019	- Зэс, молибдений баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх ионжуулсан усны шүлтлэгийн хэмжээ /рН10-12 хүртэл/ болон молибдений гарцыг нэмэгдүүлэх технологийн туршилт, судалгаа - Баяжуулах үйлдвэрүүдэд усны рН-ын хэмжээг нэмэгдүүлэхэд шохойн чулууны хэрэгцээг бууруулах шаардлагыг тодорхойлох, оновчлолыг гаргах
21.	Түүхий нүүрснийг шахсан болон шингэрүүлсэн нийлэг байгалийн	- Нүүрснээс шингэрүүлсэн нийлэг байгалийн хий үйлдвэрлэх технологи /нийлэг байгалийн хий гаргах даралтат урвалын төхөөрөмжийн загвар/

	хийгээр орлуулах технологийн судалгаа 2018-2019	- Шингэрүүлсэн нийлэг байгалийн хий гаргах процессын катализатор, үйлдвэрлэх технологи - Шахсан ба шингэрүүлсэн нийлэг байгалийн хийг хэрэглээнд нэвтрүүлэх арга
22.	Хатуу ашигт малтмалын ордуудад /алт, газрын ховор элемент, жонш, нүүрс/ хайгуулын ажил гүйцэтгэх, нөөцийг тайлагнах аргачлал 2018-2020	- Тухайн төрлийн ашигт малтмалын ордын геологи, түүний эрэл ба хайгуулын арга аргачлал боловсруулах - Тухайн төрлийн ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал бүхий хайгуулын ажлын үр дүнг тайлагнах аргачлал, зөвлөмж
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		
23.	Амьтан, ургамлын гаралтай тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх технологи 2018-2020	- Арвин ашиг шимт үнээний сүүний гарцыг нэмэгдүүлэх ургамлын гаралтай бэлдэц гарган авах - Үр тариа, төмсний гидролизийн дрожжийн бэлдмэл гарган авах, үйлдвэрлэх технологи боловсруулах - Малын ашиг шимийн тодорхой үзүүлэлтийг дээшлүүлэх үйлчилгээтэй, малын дайвар бүтээгдэхүүний уургийн олон нэрийн гидролизат гарган авах технологи боловсруулах - Саалийн үнээнд зориулсан уураг, эрдсээр баяжуулсан багсармал тэжээлийн жор боловсруулах - Бүтээгдэхүүн тус бүрийн найрлага, биологийн идэвхийн үнэлгээ, стандарт, тэжээлд ашиглах, хадгалах талаар заавар, зөвлөмж боловсруулах
24.	Эмийн зохисгүй хэрэглээнээс үүдэн малын биед үүсэх эмгэг өөрчлөлтүүдийг илрүүлэн судалж, <i>Pharmacovigilance</i> /сэрэмжлүүлэг/-ийн тогтолцоог мал эмнэлэгт нэвтрүүлэх 2018-2020	- Эмүүдийн зохисгүй хэрэглээний нөлөөгөөр үүсэх эмгэг өөрчлөлтүүдийг /харшлын, эмнэл зүйн, эмгэг анатомийн, эд, эсийн түвшний болон нянгийн эсрэг тэсвэрт чанарын/ 8-10 үзүүлэлтээр тогтоох үнэлэх арга боловсруулах - Өргөн хэрэглээний, гормоны болон антибиотикийн бүлгийн 6-8 эмийн хэвийн бус үйлдлийг илрүүлэх аргууд /10 хүртэл/ боловсруулах - Эмийн зохисгүй хэрэглээг илрүүлэх заавар, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх - Мал эмнэлэгт хэрэгжүүлэх фармаковигиланс /сэрэмжлүүлэг/-ын тогтолцооны загвар гаргах

25.	Дархлаа дэмжих хүчлүүрт вакцин, оношлуур болон эмчилгээний биобэлдмэлийн технологи боловсруулах 2018-2020	- Сахуу, бог малын сохор догол өвчнөөс сэргийлэх вакцины загвар, /хамгаалах идэвх 80%-иас доошгүй байх/ - Малын цусан халдвар, дотрын халдварт хордлого өвчнийг эмчлэх эмчилгээний биобэлдмэлийн технологи - Адууны ям, бог малын сохор догол зэрэг өвчнийг түргэн (4-10 минутийн хугацаанд үр дүн гарах) оношлох оношлуурын технологи, - Хүнсний халдварт хордлого үүсгэгч <i>Salmonella spp</i>, <i>E. coli</i>, <i>Campylobacter spp</i>, <i>Listeria spp</i> зэргийг түргэн хугацаанд (4-10 минутийн хугацаанд үр дүн гарах) ялган таних Латекс наалдуулах урвалын технологи, /4 төрлийн үүсгэгч/ - Мал, амьтан /сарлаг, тэмээ, цаа буга, адуу/-ны бруцеллөз өвчин үүсгэгчийн молекул эпидемиологийн судалгаа /4 төрлийн мал, амьтан/
26.	Монгол орны хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хамгаалах, судалж ашиглах 2018-2020	- Монгол орны Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн <i>ex situ</i> цуглуулгыг стратегийн гол ач холбогдол бүхий үр тариа, буурцагтан, олон наст модлог ургамал, тос техник, хүнсний ногооны 1500 шинэ сорт дээжээр баяжуулах - Үрийн генийн санд хадгалж байгаа таримал ургамлын ангилал зүйг шинэчилж, 2000 сорт дээжийн үрийг сэргээх - Стратегийн хүнс тэжээлийн таримал арвай, бог будаа, хошуу будааны 300 дээжид молекул генетикийн судалгаа хийж олон янз байдлыг тогтоох - Үрийн генбанкд байгаа хүнсний гол ач холбогдол бүхий үр тариа, буурцагтан, хүнсний ногооны 1000 дээжийн амьдралт, хадгалалтын нөхцөлд мониторинг хийж, үрийг амьдаар тогтвортой хадгалах горимыг судалж тогтоох - Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн бүртгэл мэдээллийн үндэсний цахим систем шинээр байгуулж ашиглах - Хүнс, хөдөө аж ахуйн өргөн хэрэглээний буурцагт болон хүнсний ногооны 5 таримлын дескриптор боловсруулж ашиглах
27.	Жимсний селекцийн судалгаа, ирээдүйтэй сортын суулгац үржүүлэг 2018-2020	- Чацарганы байгалийн популяциас сонгосон 10-аас доошгүй хэлбэрүүдэд фенотипийн судалгаа хийж монгол чацарганыг брэнд болгох ашигтай шинж бүхий хэлбэр сонгох

		- Эрлийзжүүлэг болон сонголтын аргаар үхэр нүд, гүзээлзгэний 3-5 эх материал гаргах - Жимсгэний 3-4 төрлийн таримлын сортуудад ган, халуун, хүйтэн тэсвэрийн судалгаа хийж, стресст тэсвэртэй сорт сонгож шалгаруулах - Монгол оронд тариалагдах жимс жимсгэний нэр төрлийг олшруулж саскотуун, далан хальс, улаалзгана, нэрс, лийр, алим, чавга, үхэр нүд, интоор зэрэг таримлын 1,0 га генофондийн талбай байгуулах - Жимс, жимсгэний ургамлын 7 төрлийн таримлын нутагшсан, ирээдүйтэй сортын 8000ш суулгац үржүүлж үйлдвэрлэлд нийлүүлэх; - Жимс, жимсгэний 2-3 сортыг Улсын сорт сорилтонд шилжүүлж баталгаажуулах - Жимсний шинэ нэр төрлийн таримал тариалах технологи боловсруулах
28.	Монгол орны газар тариалангийн төвийн бүсийн ургамал хамгааллын бодисын хэрэглээний мониторинг болон үлдэгдлийн судалгаа, тэдгээрийг саармагжуулах, эрсдлийн үнэлгээ хийх технологи 2018-2020	- Газар тариалангийн төвийн бүсийн таримал ургамал болон тариалангийн талбайн хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийг тодорхойлох - Газар тариалангийн төв бүсэд хэрэглэж буй пестицидийн хэрэглээнд мониторинг судалгаа хийх технологийг боловсруулах - Монгол оронд хөдөө аж ахуйн зориулалтаар хэрэглэгдэж байсан зарим удаан задардаг органик бохирдуулагчийн үлдэгдлийг тогтоож, тэдгээрийн задралын хугацааг тодорхойлох - Газар тариалангийн төвийн бүсийн пестицидийн хэрэглээнд эрсдлийн үнэлгээ хийх шаардлагуудыг тодорхойлж, эрсдлийн үнэлгээ хийх - Тариалангийн талбайн хөрсөн дэх ургамал хамгааллын бодис, бордооны үлдэгдлийг саармагжуулах дэвшилтэт технологи боловсруулах
29.	Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа услалтын тоног төхөөрөмжийн ашиглалт технологийн үзүүлэлт, бүтээл, эрчим хүчний	- Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа услалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн хийц технологийн горимын судалгааг сүүлийн 20 жилийн байдлаар тодорхойлж, өөрийн орны үйлдвэрлэлийн нөхцөлд тохирсон усалгааны систем, усалгааны тоног төхөөрөмжийн сонголт хийх аргачлал боловсруулж, зөвлөмж гаргах

	зарцуулалт, засвар техникийн үйлчилгээний норм, нормативийг тогтоох судалгаа 2018-2020	- Манай оронд ашиглаж байгаа усалгааны систем, тоног төхөөрөмжийн ашиглалт, технологийн үзүүлэлт болох усалгааны горим, бүтээлийн норм, эрчим хүчний зарцуулалт, засвар, техникийн үйлчилгээний норм нормативыг тогтоох судалгааг усалгааны системийн машин тоног төхөөрөмжийг төрөл тус бүр дээр тогтоож үйлдвэрлэлд мөрдөх үлгэрчилсэн норм боловсруулж зөвлөмж боловсруулах /марк тус бүрээр үлгэрчилсэн норм, түүнийг дагаж мөрдөх зөвлөмж боловсруулах/ - Ургац программчлалын арга дээр үндэслэн монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлийн нөхцөл, усны нөөц, хөрсний төрөл, талбайн ангиллаас хамааруулан усалгаатай тариалангийн механикжсан технологийн үлгэрчилсэн картыг таримлын төрөл тус бүр дээр боловсруулж, усалгаатай тариалангийн бүтээгдэхүүний өөрийн өртөг, эдийн засгийн үр ашиг тооцох, тогтвортой ургац авах арга замыг тодорхойлох - Өрхийн болон бага талбайтай аж ахуйн газар тариалангийн үйлдвэрлэлд тохирсон нөөц хэмнэх технологийн шаардлагыг хангасан бага оврын усалгааны тоног төхөөрөмжийн загвар зохион бүтээж, үйлдвэрлэх техникийн баримт бичгийг бүрдүүлэх, баталгаажуулах
30.	Монгол Улсын бэлтгэлийн сүүний нийлүүлэлтийг боловсронгүй болгох, суурь үнийн зохистой зарчмыг тогтоох судалгаа 2018-2020	- Монгол Улсын сүү бэлтгэлийн гол бүс нутгийг хамарсан түүхий эдийн нөөцийг газарзүйн бүс, хот, хөдөө, улирлын ялгаа бусад хүчин зүйлүүдтэй холбон судлах - Сүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтэд тулгуурлан бэлтгэлийн сүүний суурь үнийг тогтоох дэвшилтэт аргазүй-зөвлөмж, - Сүү, сүүн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэлтгэлийн сүүний чанар, эрүүл ахуйн үзүүлэлтүүд, үнэ, урамшуулал зэрэг хүчин зүйлүүдтэй холбон судлах
31.	Бэлчээрийн болон байран маллагаатай мал, амьтны бодисын солилцоог дэмжих эмчилгээ, сэргийлэлтийн	- Бэлчээрийн болон байран маллагаатай мал, амьтанд тохиолдож буй бодисын солилцооны болон үржлийн эмгэгийг эмчлэх, сэргийлэх шинэ эм, бэлдмэлийн технологи боловсруулах - Ургамлаас хоёрдогч метаболитыг ялган авах, цэвэршүүлэх, химийн аргаар микроэлементээр баяжуулах, шинэ үеийн эм, бэлдмэлийн загвар боловсруулах

	бэлдмэлийн шинэ технологи 2018-2020	- Шинэ эм, бэлдмэлийн биологийн идэвхийг шалгах, хэрэглэх арга
Эрүүл мэндийн яам		
32.	Улаанбаатар хотын хүн амын дундах тархины харвалт өвчний регистр судалгаа - өвчлөл, нас баралтын тархвар зүйн мониторинг аргыг туршин нэвтрүүлэх 2018-2020	- Улаанбаатар хотын хүн амын дунд тархины харвалт-инсультгийн эпидемиологийн үндсэн үзүүлэлтүүд үүнд, өвчлөлийн төвшинг орчин үеийн регистрийн аргаар 2 жилийн дунджаар, 1000 хүн амд ноогдох давтамжаар, 10 орчим насны ангилалаар, хүйсний ялгаагаар судлан тогтоох - Тархины харвалтын эмнэлзүйн үндсэн хэлбэрүүдийн (тархины эдийн цус харвалт, тархины шигдээс, тархины бүрхүүлийн цус харвалт, лакун харвалт, тархины гүний инфаркт) эзлэх хувийг тодорхой хугацааны хүрээнд шинээр гарсан тохиолдлын дотор судлан магадлалтай хувь хэмжээ тогтоох - Тархины ишемийн (шигдээс) харвалтын эмгэг жамын үндсэн хэв шинжүүд (тромбозын, эмболийн, тромб-эмболийн, гемодинамийн гэсэн хэлбэрүүдийн хувь хэмжээ, ишемийн болон геморрагийн харвалтын харьцаа)-г тогтоох - Регистр судалгаагаар эмнэлэгт болон хүн амд суурилсан судалгааг хийж үзүүлэлтүүдийг харьцуулан дүгнэлт гаргах - Тархины эдийн цус харвалтын тархин дахь үндсэн байрлал, судасны зарим өвчинтэй (артерийн гипертони, аневризм гм) холбоотой үүсдэг цус харвалтын өвөрмөц байрлалуудыг илрүүлэх - Улаанбаатар хотын хүн амын дунд хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулан тархины харвалтын (түүний хэв шинжүүдийн) өвчлөлийн давтамжийн хөдлөлзүй, ялангуяа сүүлийн 10 жилийн хандлагыг (ихэссэн, багассан, нэг түвшиндээ гм) тогтоож дүгнэх - Монгол орон дахь тархины харвалтын гол шалтгаан, хүчин зүйлсийг илрүүлэн тогтоох, сэргийлэх арга, зөвлөмж боловсруулах - Ази, Европ, Америк тивийн орнуудад хийгдсэн ижил төстэй судалгаануудын үзүүлэлтүүдтэй харьцуулан судалж, тархины харвалтын өвчлөл, нас баралт Монгол орон (Улаанбаатар)-д ямар төвшинд байгааг тогтоох
33.	"Next Generation Sequencing" технологит	- Бодисын солилцооны хам шинжийн оношилгоо, эмчилгээний протокол боловсруулах

	суурилсан Монгол хүний бодисын солилцооны хам шинжийн эрсдэл өндөр генийн мэдээллийн санг бүрдүүлэх, физиологийн онцлогтой уялдуулсан генийн оношилгоог нэвтрүүлэх 2018-2020	- Генийн эмнэлзүйн оношилгооны стандарт боловсруулж батлуулах - “NGS-Metabolic Syndrom” оношилгооны патент - Монгол хүний насны онцлогт тохирсон генийн мэдээллийг эрүүл мэндийн цахим системд оруулж, ашиглах боломжийг бүрдүүлэх
34.	Хүүхдийн хорт хавдрын оношилгоонд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх 2018-2020	- Хүүхдийн хавдрыг иммуногистохимийн аргаар ялган оношлох оношилгооны заавар боловсруулах - Хүүхдэд зонхилон тохиолдох хавдрын эмчилгээний удирдамж боловсруулж батлуулах - Монгол оронд зонхилон тохиолдох хүүхдийн хавдрын тохиолдлын давтамжийг тогтоох, өвчлөлийн бүтэц тодорхойлох - Хүүхдийн хорт хавдрын тохиолдлын амьдрах чадварыг судалж, олон улсын судалгааны үр дүнтэй харьцуулах
35.	Уламжлалт анагаах ухаанд хэрэглэж ирсэн эмт бодис, эмүүдэд тулгуурлан цус шингэлэх, сахар бууруулах, нянгийн эсрэг үйлдэлтэй шинэ эм бүтээх судалгаа 2018-2020	- Шинээр судалж буй болон уламжлалт эмт бодисууд, уламжлалт эмүүдийн хими-фармакологийн судалгааг хийж, эмнэл зүйн судалгаанд шилжүүлэх - Цус шингэлэх, сахар зохицуулах, нянгийн, үрэвслийн эсрэг үйлдэлтэй шинэ эм бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх - Уламжлалт анагаах ухааны эмчилгээнд чихрийн шижин өвчний үед сахар бууруулах зорилгоор хэрэглэж ирсэн эмүүдийн найрлаганд орсон биологийн идэвхит бодисууд, тэдгээрийн фармакологийн үйлдлийн төстэй болон ялгаатай талуудыг судалж үйлдлийн мөн чанарыг тогтоож, эмчлэн сэргийлэх зорилгоор хэрэглэх үндэслэлийг тогтоох - Атеросклероз, тромбофлебит өвчний үед цус шингэлэх үйлдэлтэй уламжлалт жор найрлагын үйлдлийн мөн чанарыг туршилтын амьтан дээр тохиромжтой загвар үүсгэн судлах

		- Уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг эмийн түүхий эдүүдээс хоолой залгиурын үрэвслийг эмчлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйлдэлтэй шинэ эм бүтээх - Ургамлын гаралтай түүхий эдүүдээс халдварт өвчний нянгийн эсрэг өвөрмөц үйлчилгээтэй шинэ эм бүтээх
36.	Өсвөр үеийнхний эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх асуудал 2018-2020	- Өсвөр үеийнхний хоол тэжээлийн өнөөгийн байдал, үнэлгээ - Өсвөр үеийнхний бие бялдрын үндсэн үзүүлэлтийн хэвийн хэмжээ-нормограмм (нас, хүйсээр) - Хүчирхийлэлд өртсөн өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар - Амиа хорлох оролдлого хийсэн өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар - Өсвөр насны жирэмсэн охидод үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар - Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж - Өсвөр үеийн эрүүл мэндийн цахимд суурилсан тандалтын тогтолцоог бий болгох
37.	Тархины харвалттай өвчтөний урт хугацааны сэргээн засах эмчилгээний технологи 2018-2020	- Тархины харвалттай өвчтөнд урт хугацааны сэргээн засах эмчилгээг хийхэд зарцуулагдах зардлын өртөгийг тооцож гаргах - Тархины харвалтын дараах сэргээн засах эмчилгээний удирдамжийг шинэчлэн батлуулах
38.	Монгол Улсад хэрэгжиж буй В гепатитын эсрэг дархлаажуулалтын дараахь урт хугацааны дархлаа тогтоц, нөлөөлөх хүчин зүйлс, сайжруулах арга зам 2018-2019	- Монгол улсын хот хөдөөгийн хүүхэд, залууст гепатит В вирусийн халдварыг илрүүлэх - В гепатитын вакцины дараахь дархлаа тогтоцыг үнэлэх /насанд хүрэгсэд болон хүүхдийн дархлаа тогтоцын үзүүлэлтийг тогтоох/ - Дархлаа тогтоцын үзүүлэлтийн нөлөөлөх хүчин зүйл бүрээр зөвлөмж боловсруулах - Вакцинжуулалтанд хэрэглэж байсан вакцины чанарт эргэмж үнэлгээ өгөх - В гепатитын халдвартай эхээс урагт халдвар дамжих эрсдэлийг бууруулахад вакцинжуулалтын нөлөөг үнэлсэн дүгнэлт гаргах

39.	Шүд цоорлын эсрэг нян орлуулах болон пробиотик шинэ бүтээгдэхүүн гарган авах 2018-2020	- <i>Streptococcus mutans</i>-ийн шүд цооролт үүсгэх хоруу чанаргүй омог гарган авах судалгаа - Сүү, сүүн бүтээгдэхүүнээс пробиотик шинж чанар бүхий нутгийн омог гарган авах судалгаа - Хоруу чанаргүй омог болон пробиотик омгийн холимгийг сүү, сүүн бүтээгдэхүүнд шүд цоорлоос сэргийлэх бүтээгдэхүүний технологи боловсруулах, дээж сан бүрдүүлэх
40.	Зүрхний дутагдал өвчний оношилгоо, эмчилгээ, хяналтын цогц менежментийг хэрэгжүүлэх 2018-2019	- Зүрхний дутагдал өвчний талаарх үндэсний хэмжээний суурь судалгааны сан, эмнэлзүйн нотолгоо бий болгох - Зүрхний дутагдлын цочмог болон архаг үеийн эмчилгээний менежментийг боловсронгуй болгож, оношилгоо эмчилгээний удирдамж, заавар боловсруулах, батлуулах - Олон улсын жишигт хүрсэн зүрхний дутагдлын эмчилгээ, хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх - Монгол Улсын хэмжээнд зүрхний дутагдлын эмнэлэгт суурилсан цахим бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгож нэвтрүүлэх -
Эрчим хүчний яам		
41.	Монгол улсын түлш, эрчим хүчний 2014-2018 оны баланс боловсруулах судалгаа 2018-2019	- Түлш, эрчим хүчний нэгдсэн баланс боловсруулах олон улсад хүлээн зөвшөөрөгдөх аргачлалыг боловсруулах - Түлш, эрчим хүчний нэгдсэн балансын анхдагч өгөгдөл, статистикийн мэдээллийг цуглуулах - Түлш, эрчим хүчний нөөцийг (нүүрс, занар, уран, шатдаг хий, нар, ус, салхи гэх мэт) тодорхойлох - Түлш, эрчим хүчний нөөцийн тээвэрлэлт, боловсруулалт, энергийн хувиргалт, энергийн бус хэрэглээ, дамжуулалт, түгээлт, ашиглалтын алдагдлын судалгаа хийх - Монгол улсын эрчим хүчний хэрэглээг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх салбар чиглэлийн ангиллаар тооцоолон гаргах - Түлш, эрчим хүчний бүтээгдэхүүний төрөл тус бүрээр олон улсад дагаж мөрдөж буй нэгж хэмжигдэхүүнд шилжүүлж нэгдсэн балансыг гаргах

Онцгой байдлын ерөнхий газар		
42.	Хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал 2018-2020	- Орон нутгийн дасан зохицох байдлыг нэмэгдүүлэх, ой, хээрийн түймэр, зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, таамаглалыг хиймэл дагуулын мэдээг үндэслэн хийх - Онцгой байдлын ерөнхий газрын болон орон нутгийн онцгой байдлын газрын ой, хээрийн түймэртэй тэмцэх, зохион байгуулах үйл ажиллагаанд хиймэл дагуулын мэдээллийг ашиглах - Гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэр, зудын эрсдлийн үнэлгээ хийх чадавхийг дээшлүүлэх - Ой, хээрийн түймрийн гамшгийн менежментэд сансрын технологийг ашиглаж, салбар байгууллагын уялдаа холбоог сайжруулах
43.	Гал унтраагч бодис гарган авах туршилт судалгаа 2018-2019	- Манай орны онцлогт тохирсон ахуйн чанартай бага хэмжээний галыг унтраахад хэрэглэгдэх хөнгөн, ашиглахад хялбар бодисын шийдэл - Импортыг орлох, гал унтраах бодис гарган авах технологи

--oOo--

---o0o---